

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
12 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-11
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-46
	1.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /эцсийн хэлэлцүүлэг/	14-16
	2.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /эцсийн хэлэлцүүлэг/	16-17
	3.Хуулийн төсөл эцэслэн батлах	17-22
	4.“Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх ашгийг хангуулах арга хэмээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /хэлэлцэх эсэх, хаалттай/	22-23
	5.Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг сонсох	23-31
	6.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /хэлэлцэх эсэх/	31-46

### ***Хураангүй тэмдэглэл***

#### ***Гурав.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Золбоо нар байлцав.

**1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд:**

**Г.Занданшатар:** 1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 10

Бүгд: 53

81.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн саналыг дэмжсэнд тооцов.

*Хамт өргөн мэдүүлсэн:*

2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 9

Бүгд: 53

83.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 13

Бүгд: 53

75.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 15

Бүгд: 53

71.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 9

Бүгд: 54

83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 47  
Татгалзсан: 7  
Бүгд: 54

87.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 7  
Бүгд: 55

87.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46  
Татгалзсан: 9  
Бүгд: 55

83.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 7  
Бүгд: 55

87.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47  
Татгалзсан: 8  
Бүгд: 55

85.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46  
Татгалзсан: 9  
Бүгд: 55

83.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47  
Татгалзсан: 8  
Бүгд: 55

85.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 9

Бүгд: 56

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 7

Бүгд: 56

87.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 9

Бүгд: 56

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 10

Бүгд: 56

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 10

Бүгд: 56

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 10

Бүгд: 57

82.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 9

Бүгд: 57

84.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20.Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 11

Бүгд: 57

80.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

*Холбогдуулан боловсруулсан:*

21.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 7

Бүгд: 57

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

22.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 9

Бүгд: 57

84.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

23.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 11

Бүгд: 57

80.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

## ***Дэлгэрэнгүй тэмдэглэл***

### **1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл**

1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулъя. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн суудалдаа сууж саналаа өгөөрэй, Баделхан, Батсуурь, Баттөмөр Бейсен, Болорчулуун, Ганбат, Доржханд, Өнөрболор, Цогтгэрэл, Чинбүрэн, Чинзориг нарын гишүүд бүртгэлд орсонгүй. Бүртгэлд ороогүй гишүүд бүртгэлдээ ороорой.

Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт

43 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнийг дэмжсэн тооцъё.

*Хамт өргөн мэдүүлсэн:*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

2.Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт.

Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Дарга аа, би сая уг нь дэмжиж санал өгсөн юм. Тэгээд энэ кноп болсонгүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч.

**Г.Зандншатар:** Дамдинням гишүүний горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

45 гишүүний санал буюу 83.3 хувиар Дамдинням гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

- Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцно тул санал хураалтыг дахин явуулъя.
- 47 гишүүн дэмжиж 87 хувийн саналаар хууль эцэслэн батлагдана.
- 4.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.
- 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.
- 5.Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт
- 48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.
- 6.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.
- 48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.
- 7.Төв банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт
- 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.
- 8.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.
- 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.
- 9.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.
- 47 гишүүн дэмжиж хууль, эцэслэн батлагдлаа.
- 10.Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт
- 47 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.
- 11.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт
- 49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.
- 12.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт
- 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.
- 13.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.
- 48 гишүүн дэмжиж, хууль эцсийн батлагдлаа.
- 14.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт байна.
- 48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.



15.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн баталлаа.

16.Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

17.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

18.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

19.Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

*Холбогдуулан боловсруулсан:*

20.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт

50 гишүүн дэмжиж, тогтоол эцэслэн батлагдлаа.

21.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

22.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ийнхүү Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулсан нийт 22 хуулийн төслийг эцэслэн баталлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах гэсэн Үндсэн хуулийн бүрэн эрхийг бодитойгоор амилуулах, мөн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 6.2, 25.1.7 болон 28.2-т оруулсан өөрчлөлтийг амилуулж үр дүнтэй хяналт буюу хянан шалгах бүрэн эрхтэй суурилсан эргэх холбоотой хууль тогтоох, төлөөлөх бүрэн эрхээ хэрэгжүүлэх байдлаар Монгол Улсын парламентыг хөгжлийн дараагийн шатанд хүргэх зорилготой юм. Ийнхүү сонгодог парламентын тогтолцоог хөгжүүлэх, төлөвшүүлэх бидний эрхэм зорилго, нэг алхмаар урагшилж байна. Иж бүрэн, үнэн зөв, бодитой мэдээлэл гэдэг бол зөв шийдвэр гаргах амжилтын үндэс байдаг.

Энэ хууль гарснаар Улсын Их Хурлын гишүүн, түүний цаана ард түмэн, төрийн аливаа шийдвэрийн биелэлтийн байдал, хэрэв биелэлт муу бол алдаа дутагдал, зөрчил, түүний шалтгаан нөхцөл, юу хийвэл тухайн зөрчил нь арилах, гацаанд гарах талаар бодит зураглал гаргах бүрэн боломж бүрдэх юм. Ингэснээр бидний батлах хууль, байгаа оносон, бодитой асуудлаа шийдэж чаддаг чанар, үр нөлөө сайжирна. Төр өөрөө гацаах ч биш, дэмжигч хөгжүүлэгч хүчин зүйл болоход энэ хууль бус, бодитой хувь нэмрээ оруулах ёстой. Хуулийн чанар тоондоо бус, асуудлыг шийдвэрлэх чадвартаа байдаг. Чанартай хууль батлах үндсэн нь одоо байгаа нөхцөл, түүнээс үүдэн илэрч байгаа нийгмийн үзэгдэл, түүний учир шалтгаан, гарц шийдлийг тогтооход шаардлагатай бодит үнэн, зөв иж бүрэн мэдээлэл юм.

Нөгөө талаас энэ хууль, иргэний мэдэх эрх, түүнээс эх сурвалжтай парламентын хяналт шалгалтын бүрэн эрхээр дамжуулж төрийн албыг бүх шатанд нь хариуцлагажуулах хөшүүрэг болох юм. Мөн Монгол Улсын парламент эдүгээ 30 насанд хүрч, танин мэдэхүй үеэ туулсан бол дараагийн үе рүүгээ орох цаг үе ирсэн байна.

Хуулийн онцлох ач холбогдлоос дурдвал нэгдүгээрт, тэнцвэртэй, бодит мэдээлэл, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурал Хяналт шалгалтын түр хороо байгуулж, нийтийн эрх ашгийг хөндсөн тухай асуудлаар холбогдох мэдээллүүдийг хуулийн хүрээнд ил болгож, иргэний мэдэх эрхийг хангана. Тодруулбал олон улсын парламентын үйл ажиллагаанд нэгэн жишиг болон тогтсон investigate буюу мөрдөн шалгах сонсгол хийх замаар тухайн асуудалд холбогдох гэрч, албан тушаалтан, шинжээчийг Улсын Их Хуралдаа дуудаж, тайлбар, мэдүүлэг авах, тусгай шинжээч хянан шалгагч томилох замаар нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг тал бүрээс нь шинжлэн судалж, бодит мэдээллийг ард түмэндээ ил болгох онцгой ач холбогдолтой юм.

Хараат бус мэдээллийг хангана. Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасан хууль, тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ олон улсын байгууллагын мэдээллийн эх сурвалжаас болон гүйцэтгэх эрх мэдлээс хараат бусаар хэрэгжүүлэхээр гэж Олон Улсын Парламентын Холбооноос заасан нь Улсын Их Хурлын хуулийн хэрэгжилтэд бодитой, үр нөлөөтэй хяналт тавих боломжийг бүрдүүлж байгаа юм.

Гуравдугаарт, энэ хариуцлагыг сайжруулна. Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг хуульчилсан.

Дөрөвдүгээрт бол, нэр дэвшигчийн сонсгол хийснээр Улсын Их Хурал бол өөрсдийнхөө эрх мэдлээс Улсын Их Хурлын дарга татгалзаж байна гэсэн үг. Цүнх баригч, хэн нэгэн хүнийг дэвшүүлдэг биш, заавал хуульд нийцсэн, шаардлага хангасан хүнийг дэвшүүлж, нээлттэй сонсголоор оруулж томилох ийм нөхцөл бүрдэж байгаа юм. Ингэснээрээ бол муу хүн томилогүй байх энэ боломж бол ямар ч байсан бий болж байна.

Тавдугаарт, төрийн бодлогын уялдаа холбоо, залгамж чанар хангагдах бодит нөхцөл буюу Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сантай болох ийм зохицуулалтууд хийгдсэнээр улс төрийн сонгуулийн циклиэс, аль эсвэл хэн олонх байхаас үл хамааран төрийн ой санамж тасралтгүй байх ач холбогдолтой хяналт шалгалтын төрөлжсөн мэдээллийн нэгдсэн саналтай болно. Ийм ач холбогдолтой хуулийг өнөөдөр эцэслэн баталлаа.